



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/393.

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах байгууллагын хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын нутаг дэвсгэр (Ж.Пэлжээ-1-116)-д байршилтай "Тогтвортой хөгжил-Дундговь" төрийн бус байгууллага (РД:1028529)-ын төрийн үйлчилгээний зориулалттай 970 м.кв (0,09га) газрыг Дундговь аймгийн Боловсрол, соёл, урлагын газар (9033696)-т зориулалтаар нь шилжүүлж 30 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2006 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 302 дугаар захирамжийн Тогтвортой хөгжил – Дундговь төрийн бус байгууллага-т холбогдох хэсэг мөн газар эзэмших 0077114 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210539